



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/26

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3 дугаар зүйлийн "н", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: - Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: - Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд: - Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Мэргэжлийн хяналтын Газрын дарга
- Цагдаагийн газрын дэд дарга
- Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч
- Тухайн сумын Засаг дарга

Хоёр. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, төлөвлөгөөний биелэлт, тайланг тогтоосон хугацаанд холбогдох газар хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Гурав. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу орон нутагтаа тодорхой арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213054